



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 11 сарын 18 өдөр

Дугаар А/252

Улаанбаатар хот

“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн”
нийтлэг журам, зааварчилгаа батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.6 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нийтлэг журам”-ыг нэгдүгээр, “Албан тасалгаанд мөрдөх аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г хоёрдугаар, “Албан томилолтоор ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж, журам зааварчилгааг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Агентлагийн газар, хэлтсийн дарга нар, нийт албан хаагчдад үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, дотоод аудитын хэлтэс (Х.Оюунбилэг)-т даалгасугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА



ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН НИЙТЛЭГ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Цаг уур, орчны шинжилгээний газрын нийт албан хаагчдын албан үүргээ гүйцэтгэхдээ эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн харилцааг зохицуулахад оршино.

1.2 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг жил бүр зохион байгуулах бөгөөд байгууллагын нэгжийн албан хаагчид бүгд хамрагдсан байна.

1.3 Өвлийн улиралд өөрийн хариуцсан объектын гадаад орчны цэвэрлэгээ үйлчилгээг бүрэн хариуцаж цас бусад хог бохирдлыг цэвэрлэх ба хүн хальтрах аюулаас урьдчилан сэргийлж цас, мөсийг заавал цэвэрлэсэн байна. Их хэмжээний цас орсон тохиолдолд байгууллагаас хүн хүч нэмэгдүүлэн цасыг цэвэрлэж байх ингэхдээ ногоон байгууламжийн хэсэгт цасыг цуглуулах хүн, автомашины хөдөлгөөнд саад урчуулахгүй байдлаар холдуулсан байна.

1.4 Цахилгаантай холбоотой гэмтлийг өөрөө дур мэдэн засварлахыг хатуу хориглоно. Заавал мэргэжлийн цахилгаанчинд мэдэгдэнэ.

1.5 Ажилдаа ирж очих замдаа замын хөдөлгөөнд явган, автомашинтай аль ч хэлбэрээр оролцсон замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрмийг баримтлан зорчих, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлнэ.

1.6 Агентлагын газар, хэлтсийн дарга нар аюулгүй ажиллагааны зааварчилгааг улирал бүр тогтмол өгч бүртгэлийг хөтөлж байна.

1.7 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажлын явц байдал, өгөгдсөн үүрэг даалгавар, тушаал шийдвэрт тусгагдсан заалтуудыг Агентлагын газар, хэлтсийн дарга нар цаг хугацаанд нь хэрхэн гүйцэтгэсэн талаар гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэнд оруулан тайлагнана.

1.8 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн журам, сахилга бат зөрчигдсөн болон түүнийг арилгахтай холбогдсон асуудлаар агентлагийн газар хэлтсийн дарга, харьяа байгууллагын даргын илтгэл сонсголыг Газрын даргын зөвлөлийн хурлаар авч хэлэлцэн шийдвэрлэнэ.

1.9 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн журмыг зөрчсөн ажилтанд Хөдөлмөрийн тухай хууль, байгууллагын дотоод журамд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Хоёр. Ажлын байран дахь зааварчилгаа

2.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа нь анхан шатны болон давтан (ээлжит) зааварчилгаа гэсэн 2 хэлбэртэй байна.

2.2 Анхан шатны зааварчилгааг шинээр ажилд орсон ажилтан, үйл ажиллагаатай танилцахаар ирсэн ажилтан, оюутан, үйлчлүүлэгчид өгнө.

2.3 Давтан зааварчилгааг ажилтанд өмнө олгосон мэдлэгийг бататгах, баяжуулах зорилгоор анхан шатны зааварчилгааны агуулгаар өгнө. Давтан зааварчилга нь ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байна.

2.4 Ээлжит давтан зааварчилгааг улиралд нэгээс доошгүй удаа өгнө.

2.5 Ээлжит бус давтан зааварчилгааг шинэ технологи, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нэвтрүүлэх, хөдөлмөрийн нөхцөл өөрчлөгдөх, албан томилолтоор ажиллах, нийтээр тэмдэглэх баярын өдрүүдэд хариуцлагатай эргүүл, жижүүрээр томилогдсон ажилтанд, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журам заавар шинэчлэгдэж өөрчлөгдөх үед давтан зааварчилга өгөх ээлжит хугацаанаас нь өмнө өгнө.

2.6 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, зааврыг зөрчсөн ажилтан, мөн нэг сараас илүү хугацаагаар ажлаас хөндийрч яваад эргэж ажилдаа орсон ажилтанд ээлжит бус давтан зааварчилга өгнө.

2.7 Ажлын байран дахь анхан шатны болон давтан зааварчилгааны бүртгэлийг дараах маягт 1, 2-ын дагуу бүртгэлжүүлнэ.

Ажлын байран дахь анхан шатны зааварчилгааны бүртгэлийн маягт 1.

№	Анхан шатны зааварчилгаа авсан хүний овог нэг, албан тушаал	Зааварчилгааны утга	Он сар өдөр	Шалгалтын дүн	Зааварчилгаа өгсөн хүний албан тушаал, гарын үсэг	Зааварчилгаа авсан хүний гарын үсэг	Ажиллуулахыг зөвшөөрсөн	
							Албан тушаал, овог нэр	Гарын үсэг
1.								
2.								
3.								

Ажлын байран дахь давтан зааварчилгааны бүртгэлийн маягт 2.

№	Ажилтны овог нэр, ажил, албан тушаал	Давтан зааварчилгаа өгсөн шалтгаан	Зааварчилгааны сэдэв	Он сар өдөр	Зааварчилгаа өгсөн хүний албан тушаал нэр, гарын үсэг	Зааварчилгаа авсан хүний гарын үсэг
1.						
2.						
3.						

Гурав. Ажлын байрны зохион байгуулалт

3.1 Ажлын байрны зөв зохион байгуулалт нь ажилтны аюулгүй байдал, ажлын бүтээмжтэй шууд хамааралтай тул эргономикийн шаардлагыг хангаж ажиллана.



3.2 Ажлын албан тасалгаанд (оффис) авч болох гэмтлүүдээс сэргийлэх

3.2.1 Шалан дээрх жижиг том эд зүйлүүдэд тээглэж хальтарч унах аюултай тул шалыг цэвэр байлгах.

3.2.2. Хаалганы ард аливаа зүйл байрлуулаас болгоомжлох.

3.2.3 Шингэн зүйлээр цахилгаан дамжих магадлал өндөр байдаг тул асгарсан шингэнийг дор бүр арчиж байх.

3.2.4 Өмсөх гуталдаа анхаар. Хөлөө үзүүртэй зүйлд зүсэх, дээрээс нь юм унагаах, асгах аюултай.

3.2.5 Албан тасалгаанд намхан өсгийтэй гутал өмсөх нь аюул багатай байдаг.

3.2.6 Явах газруудаар цахилгааны утаснууд байгаа эсэхийг шалгах. Хэрвээ цахилгааны утас явах хэсгээр заавал байх шаардлагатай бол зориулалтын хамгаалалтын бүрхэвч хийж аюулыг хязгаарлана.

3.3 Бичиг цаас хадгалалт, ангилалт

3.3.1 Шургуулганд хэтэрхий их ачаалал өгөх аюултай. Дээд талын шургуулганд хэт их юм тавибал тавиур урагш унах аюултай. Мөн шургуулгануудын наад хэсгээр хэт ачаалал өгөх нь мултарч унах аюулд хүргэнэ.

3.3.2 Нэг шургуулга нээхээсээ өмнө нөгөөдөхийг нь хаа. Босохдоо шургуулганд толгойгоо цохихоос сэргийл.

3.3.3 Шургуулга хааж нээх үедээ зөвхөн бариулаас нь барь, дээд ирмэгээс нь барьж гар хуруугаа хавчуулахаас сэргийл.

3.3.4 Гацсан эсвэл нээгдэхгүй байгаа тавиурыг хүчээр бүү угзар. Энэ нь нуруу гэмтээхээс гадна доторхи зүйлс нь таны дээрээс нурж унах аюултай. Хэрвээ тавиур, шургуулга нээгдэхгүй гацсан байвал засварчинд хэлж тусламж ав.

3.4 Оффисын тоног төхөөрөмжтэй ажиллах

3.4.1 Тоног төхөөрөмжүүдийн гарын авлага, зааврыг анхааралтай уншиж, зааврын дагуу тоног төхөөрөмжтэй харьцаж ажиллана. Хэрхэн ажиллуулахаа мэдэхгүй байвал тухайн төхөөрөмжөө хэзээ ч бүү ажиллуул.

3.4.2 Тоног төхөөрөмжид тохируулга хийх, цэнэглэх, горимыг нь өөрчлөх бүх тохиолдолд юуны өмнө төхөөрөмжийг унтрааж, тэжээлээс салгасан байна. Мөн богино хугацаагаар орхиж явах үед ч унтраавал зохино. Хэрэв төхөөрөмжийг шатамхай шингэнээр цэвэрлэх бол төхөөрөмжийг хөргөх, унтраах эсвэл зохих мэргэжлийн ажилтнаас заавар зөвлөгөө авна.

3.4.3 Цахилгаан гүйдлийн аюулаас болгоомжил. Цахилгаан гүйдэлд цохиулах нь амь насанд аюултайгаас гадна гал гарах аюулд хүргэнэ. Төхөөрөмж хэт халсан, утаа гарсан, оч хаясан тохиолдолд цахилгаанчинд даруй мэдэгд.

3.4.4 Цахилгаан хэрэгслийн байрлалыг ашиглахаасаа өмнө сайтар шалга. Компьютер, факсын аппарат, хувилах машинууд болон бусад нэмэлт хэрэгслүүд ажлын байрны тэгш тогтвортой гадаргууд бүрэн хүрэлцсэн байдлаар байрлах ёстой.

3.4.5 Цахилгаанаар ажилладаг төхөөрөмжүүд, компьютерийн гар, цахилгааны утаснаас шингэн зүйлийг хол байлгана.

3.4.6 Сэнс болон агааржуулагчийн гадна талын хамгаалалтын хаалтыг авч болохгүй. Эдгээр хаалтууд тогтоосон хэмжээнд нээгдэж байгааг шалга. Сэнсийг хаалганы үүд болон хүний зам дээр бүү байрлуул.

3.5 Агуулахын өрөө болон тавиурууд

3.5.1 Орчноо эмх цэгцтэй байлга. Эмх цэгцтэй байдал ажлыг хялбаршуулж аюулыг бууруулдаг. Орох гарах үүд, замыг цэвэр чөлөөтэй байлгаж тавиур, шургуулганд эд юмсаа дараалалтай бөгөөд аюулгүй байрлуулна. Тавиурууд дээр байрлуулсан эд юмс нь таазнаас 30 см-ээс доошгүй зайд байна.

3.5.2 Цэвэрлэгээ, ариутгалд ашигладаг химийн болон шатамхай бодисуудыг хадгалахдаа дээр нь нь хаяг тавь, таглаа бөглөөг нь сайтар шалга. Тухайн химийн бодисыг дагалдаж ирсэн ХАЛМ /Хор аюулын лавлах мэдээлэл/-тай танилцаж зааварчилгаа авсан байх ёстой.

3.5.3 Баглаа боодлыг задлах үед хэрэглэх аливаа зүсэх таслах зүйл аюул дагуулна. Тэдгээрийг өөрийгөө болон бусдыг гэмтээхээргүй байрлалд барьж хэрэглэнэ.

3.5.4 Ирийг нь ил гаргасан, савнаас нь гаргасан цаасны хутга, хайч, бритва зэрэг зүйлийг орхиж явж болохгүй.

3.5.5 Шатыг цонх, цонхны рам, түгжээгүй хаалга, сул хайрцаг гэх мэт тогтворгүй зүйлд тулж байрлуулж болохгүй.

3.5.6 Шатны доод суурийг тогтвортой байрлууж эсвэл хэн нэгнээр түшүүлж байх хэрэгтэй.

3.5.7 Шатаа байрлуулаад авирч буухдаа үргэлж нүүрээрээ шат руу харж буух хэрэгтэй. Гурван цэгээр хүрэлцэх дүрмийг баримтална.

3.5.8 Шатаар буух, авирах үед 2 гар үргэлж сул чөлөөтэй байна.

3.5.9 Шатны гишгүүрийг голлож гишгэнэ, аль нэг тал руу нь хэлтгий гишгэх нь аюултай.

3.5.10 Шатан дээрээс хол байгаа зүйл рүү зүтгэж хүрч болохгүй.

3.6 Хориглох зүйл

3.6.1 Байгууллагын давхар бүрийн ослын гарцыг зөвхөн ослын үед ашиглана. Өдөр тутмын үйл ажиллагаанд зориулагдаагүй бөгөөд ослын гарц орчимд эд зүйлс байрлуулахыг хориглоно.

Дөрөв. Хог хаягдлын зохицуулалт

4.1 Үйл ажиллагааны хүрээнд үүсэж байгаа хог хаягдлаас хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах зорилготой.

4.2 Байгууллагын хэмжээнд үүсэж байгаа энгийн хог хаягдлыг бууруулах, хаягдлыг дахин ашиглах ба боловсруулах газруудад өгөх, зориулалтын хогны цэгт төвлөрүүлнэ.

4.3 Энгийн хог хаягдлыг дотор нь ахуйн ба дахивар нөөц гэж ангилна. Энгийн хог хаягдалд байгууллагын албан тасалгаа, үйлчилгээний өрөө, бие засах газар, гал тогоо, агуулах, хонгил, орчны эдэлбэр газраас гарч буй сав, баглаа боодол, гар угаасны дараа хэрэглэсэн нэг удаагийн алчуураас гадна шил, цаас, цаасан хайрцаг, хөнгөн цагаан, хаягдал төмөр болон төрөл бүрийн хуванцар зэрэг ашиглаж болох дахивар нөөц хамаарна.

Хүснэгт 1: Энгийн хог хаягдал

Өнгө		ХАР	
Савлалт		Хар өнгийн нийлэг уутанд хийнэ.	
Таних тэмдэг	Энгийн хог хаягдал	Тэмдэглэгээ, таних тэмдэг шаардлагагүй	
	Дахивар нөөц		Цувраа 3 сум бүхий дахин боловсруулалтын олон улсын таних тэмдгийг хогийн сав, уутны гадна талд байрлуулна.
Хаяглалт		Шаардлагагүй	

4.4 Хог хаягдлыг зөвхөн зориулалтын хогийн сав ба шаардлага хангасан тусгай талбайд цуглуулна.

4.5 Ил задгай газар хог хаягдал хаяхыг хориглоно.

4.6 Ажлын байр, ахуйн байрны орчимд зориулалтын бус газар, автомашины зам дагуу болон тамхи татах цэгийн орчимд ил задгай газар тамхины ишний хаягдал үүсгэхгүй байхыг ажилтнууд онцгойлон анхаарч, харилцан хяналт шаардлага тавьж байна.

4.7. Хог хаягдлыг зөвхөн хог хаягдлын асуудал хариуцсан гэрээт компанийн /үйлчилгээний компани/ зориулалтын тээврийн хэрэгслээр түр хадгалах цэгээс хогийн цэгт хүргүүлнэ.

4.8. Хог хаягдлыг устгах үйл ажиллагааг зөвхөн хог хаягдлын үйлчилгээний компани гүйцэтгэх бөгөөд дур мэдэн устгал хийхийг хориглоно.

Тав. Галын аюулгүй байдал

5.1. Гал унтраах хэрэгсэл ажиллуулах талаар мэдлэгтэй байх, гал түймэр, осол аваар гарсан тохиолдолд объектыг байнгын хяналттай байлгаж энэ тухай байгууллагын даргад шуурхай мэдэгдэж хариу арга хэмжээг авах.

5.2. Гал түймэр унтраах, мэдээлэх, усан хангамж, утаа зайлуулах агааржуулалтын тоног төхөөрөмж болон тэмдэг тэмдэглэгээ, аврах гарцын схем зурагны бүрэн бүтэн байдлыг шалгаж баталгаажуулах. Тэдгээрийн нөхөн хангалтыг хийж байх. Мөн бүртгэл судалгааг гаргаж дахин төлөвлөх ажлыг мэргэжлийн байгууллагаар хянуулж хэрэгжүүлэх.

5.3 Ажлын байрны үзлэг, Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтэс болон Онцгой байдлын ерөнхий газрын үзлэг шалгалтаар илэрсэн үл тохирол, албан шаардлагын хариуг заагдсан хугацаанд залруулах ажлыг захиргааны хэлтэс хариуцна.

5.4. Галын аюулгүй байдлыг хангахад доорх үйлдлийг хориглоно. Үүнд:

5.4.1 Хаяг шошгогүй, хаяг шошго нь арилж танигдахгүй болсон гал унтраах бодисыг ашиглах

5.4.2 Гал унтраах багаж хэрэгслийг зориулалтын бусаар ашиглах

5.4.3 Гал унтраагуурыг нарны шууд тусгалд байрлуулах

5.4.4 Ашиглах боломжгүй болсон гал унтраагуурыг ажлын байранд байлгах.

Цаг уур орчны шинжилгээний газрын даргын
2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн
А/252 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

АЛБАН ТАСАЛГААНД МӨРДӨХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

Нийтлэг үндэслэл

ХАБЭА-н тухай хуулийн 18.1.1-д “ХАБЭА-н шаардлага хангасан ажлын байранд ажиллах эрхтэй” хэмээн ажилтны эдлэх эрхийг заасан байдаг.

Албан тасалгааны хөдөлмөрийн нөхцөл ажлын байрны орчин MNS4990:2015, Эргономикийн ерөнхий шаардлага хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, дэлгэц бүхий тоног төхөөрөмжтэй ажиллах эрүүл ахуй, эргономикийн ерөнхий шаардлага MNS5027:2001 стандартуудыг хангасан байна.

Оффисийн ажилтны ажлын байран дээрх хэвийн нөхцлийг хангах, эрүүл мэндийг хэвээр хадгалах зорилготой хэд хэдэн стандарт хэрэгждэг.

Үүнд:

Ажлын тогтолцооны дизайн дахь эргономикийн шаардлага MNS ISO 6385:2000

Дэлгэц бүхий тоног төхөөрөмжтэй ажиллах эрүүл ахуй, эргономикийн ерөнхий шаардлага MNS 5027:2001

ААНБайгууллага, барилга байгууламжууд гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм MNS 5566:2005

Орон сууц, иргэний барилгад байж болох шуугианы түвшин MNS 12.1009:1985

Оффисийн ажлын байрны орчны үзүүлэлтүүдэд зам талбай, дулаан, гэрэлтүүлэг, агааржуулалт, чийгшилт, тасалгааны өнгө будаг, ширээ сандал, техник хэрэгсэл зэрэг орно. MNS 5027:2001 стандартад: Тоног төхөөрөмж хананаас 1м, хоорондын зай 1,5 м-ээс багагүй. Нэг хүнд ногдох талбайн хэмжээ 6м^2 , эзлэхүүн нь 20м^3 -ээс багагүй. Нэг хүнд ногдох ажлын байрны эзлэхүүн 20м^3 бол цагт нэг хүнд 30м^3 агаар, $20\text{-}40\text{м}^3$ бол 20 м^3 агаар өгөх шаардлагатай. Цонхгүй ажлын байранд нэг цагт 60м^3 агаар солилцоо хийх шаардлагатай.

Өрөөний агаарын температур гадаад температур, улирлын байдлаас хамаарч $21\text{-}26^\circ\text{C}$ байна.

Дэлгэц бүхий тоног төхөөрөмжтэй харьцан ажилладаг хүмүүс мэдрэл сэтгэхүйн ачаалал, бие организмын үйл ажиллагаанд гарах динамик өөрчлөлт, ажиллах чадвар зэргийг харгалзан ажил, амралтын горимыг баримтлан ажиллах шаардлагатай.

Ажил эхэлснээс хойш 2 цаг тутамд 10-15 минут, дэлгэцнээс мэдээлэл унших, хянах, засварлах зэргээр байнга харьцан ажиллах үед 1 цаг тутамд 5-10 минут засварлана.

Нэг. Ажил эхлэхийн өмнөх аюулгүй ажиллагааны зааварчилгаа

1.1 Гадуур хувцсыг зориулалтын шүүгээ, өлгүүрт өлгөж ажлын байранд ажил хэрэгч байдлаар хувцасласан байна.

1.2 Ажлын ширээ, сандал, хувцасны шүүгээний бүрэн бүтэн байдал, цэвэрлэгээ,

компьютер, хэвлэх төхөөрөмж зэрэг цахилгаан хэрэгслүүдийн хэвийн ажиллагаа, галын аюулгүй байдал зэргийг шалгана.

1.3. Дээрх шалгалтуудыг хийх үед ямар нэгэн гэмтэл, үл тохирол илэрвэл холбогдох ажилтанд мэдэгдэж, засаж арилгасны дараа ажил үүргээ эхлүүлнэ.

Хоёр. Ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа

2.1. Ажлын байрын эмх цэгцийг хангаж, бичиг баримтуудыг шалан дээр болон хэт өндөрт тавихгүй байна. Компьютертэй ажиллахдаа өөртөө ажиллахад амар, чөлөөтэй зүй зохистой байхуйц байрлалыг сонгон ажиллах бөгөөд 2 цаг тутамд завсарлаж нүдээ амраана.

2.2. Хөлийн улыг шалан дээр бүрэн гишгэж байхаар сандлын өндрийг тохируулна.

2.3. Цахилгаан хэрэгсэл болон эд хогшил эвдэрч гэмтсэн үед мэргэжлийн ажилтанд хандаж, аюулгүй ажиллагааг хангаж ажиллана. Эвдрэл гэмтэлтэй цахилгаан хэрэгсэл, эд хогшил хэрэглэхийг хориглоно.

2.4. Хаягдал цаас, хог хаягдлыг зориулалтын саванд хийнэ.
Ажлын байранд ил гал гаргах (лаа, арц, хүж асаах, тамхи татах гэх мэт)-ыг хориглоно.

2.5. Албан тасалгаанд хэт чанга дуу чимээ гаргах, зүй бусаар харьцах, удирдах албан тушаалтны шийдвэргүйгээр шөнийн цагаар ажиллах зэргээр хөдөлмөрийн сахилга дэг журмыг зөрчихгүй байна.

2.6. Албан тасалгаанд цахилгаан зуух хэрэглэх, хоол хийхийг хориглоно. Ээлжийн ажилчид зориулалтын гал тогооны хэсэгт хоол хийнэ.

2.7. Ажил гүйцэтгэх явцад биед ямар нэг зовиур илрэх зэргээр эрүүл мэндэд таагүй нөхцөл үүсвэл эмч болон шууд удирдах албан тушаалтанд нэн даруй мэдэгдэнэ.

2.8. Байгууллагад гал түймрийн аюул, байгалийн гамшиг тохиолдох зэргээр онцгой байдал үүссэн нөхцөлд өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах арга хэмжээнд идэвхтэй оролцоно.

2.9. Галын анхан шатны багаж хэрэгслийг ашиглах, гал унтраах хэрэгслийн төхөөрөмжийг ажиллуулах чадвартай байна.

2.10. Гал түймрийн аюулын үед ажлын байрнаас дүрвэн гарах маршрут нөөц хаалга, гарцыг мэддэг байх, аюул ослын үед анхны тусламж үзүүлэх чадвар эзэмшсэн байна.

Гурав. Ажил дуусах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа

3.1. Албан тасалгааны бүх цахилгаан хэрэгслүүдийг цахилгааны тэжээлээс салгаж болзошгүй аюулаас сэргийлнэ.

3.2. Албан тасалгааны агааржуулагч, салхивч, халаагуурын аюулгүй ажиллагааг шалгана. Өрөө тасалгаагаа цоожилно.

3.3. Шатаар буухдаа шатны бариулаас барьж гишгүүрт хөлийн улыг бүрэн гишгэж шатан дээр халтирахаас сэргийлж, болгоомжтой бууна. Цахилгаан шатанд суухдаа хэвийн ажиллаж байгааг урьдчилан шалгаж, хаалга бүрэн нээгдсэний дараа сууна.

3.4. Ажилдаа ирж очихдоо аюулгүй, баталгаажуулсан маршрутыг сонгон аюулгүй байдлаа ханган зорчино.

Дөрөв. Уртасгагч залгууртай ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа

- 4.1 Уртасгагч залгуурыг цахилгаанаас салгахдаа кабель утаснаас нь татаж болохгүй.
- 4.2 Уртасгагч кабелиар цахилгааны байнгын буюу суурин утсыг орлуулж болохгүй.
(Байшингийн хана туурганд хадаж тогтоож болохгүй)
- 4.3 Цахилгааны залгуурыг уртасгахын тулд зориулалтын бус кабель холбохыг хориглоно. Залгасан уртасгагч болон хэт урт уртасгагч нь хүчдэлийн хэмжээг бууруулдаг бөгөөд багаж, төхөөрөмжийг гэмтээж болох аюултайг анхаарах.
- 4.4 Уян кабель болон цахилгааны утсыг шалбарах, гэмтэхээс хамгаалах, доторх утаснуудыг тусгаарладаг бүрээс нь зүсэгдсэн, урагдсан, цуурсан эсэхийг байнга шалгаж байх. Ил монтаж хийсэн цахилгааны утас нь орооцолдох, бүдэрч унах аюултай тул цахилгааны утсыг үүдний өрөө хана, тааз, шалан дээгүүр хөндлөн татаж болохгүй.
- 4.5 Мэргэжлийн болон зөвшөөрөлтэй хүн уртасгагч утсыг засаж, кабелийг солино.

Тав. Галын аюулгүй байдлыг ханган ажиллах зааварчилгаа

- 5.1 Техникийн засвар, үйлчилгээ хийдэг байранд галын аюулгүй ажиллагааны дүрмийг хатуу мөрдөнө.
- 5.2 Хаалга, гал унтраах хэрэгсэл байгаа газрын орчимд хог, хаягдал овоолох, тээврийн хэрэгслийг байрлуулах, амархан гал авалцах материалыг ил саванд хадгалахыг хориглоно.
- 5.3 Гал түймэр гарсан тохиолдолд гал унтраах мэргэжлийн анги буюу Онцгой байдлын газарт мэдэгдэж, гал унтраах хэрэгсэл рүү очиж авчран сургалтад заасан аргачлалын дагуу хэрэглэнэ.
- 5.4 Гал түймэр гарсан тохиолдолд өөрийн амь нас болон бусдын амь насыг аврах, эд хөрөнгийг хамгаалах арга хэмжээ нэн яаралтай авна.
- 5.5 Цахилгаан хэрэгслийг цахилгааны эх үүсвэрээс салгах хэрэгтэй.

----oOo----

Цаг уур орчны шинжилгээний газрын даргын
2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн
А/252 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



АЛБАН ТОМИЛОЛТООР АЖИЛЛАХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

Нийтлэг үндэслэл. Албан хаагч нь томилолтоор ажиллахаас өмнө удирдамжийн дагуу хийж гүйцэтгэх ажил, үүрэгтэй холбоотой аюулгүй ажиллагааны зааварчилгаатай зайлшгүй танилцсан байх бөгөөд өөрийн шууд харьяалан удирдах албан тушаалтнаас зааварчилгаа авч, "Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааны бүртгэлийн дэвтэр"-т тэмдэглэл хийж, гарын үсэг зурж, баталгаажуулсан байна. Зааварчилгааг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана. Албан хаагч нь орон нутагт албан томилолтоор ажиллахдаа зааварчилгаатай цахимаар танилцаж болно.

Нэг. Албан албан томилолтоор ажиллах, замд гарахын өмнөх үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа:

1.1 Албан томилолтоор ажиллахдаа томилолтын хуудас, баталсан удирдамж тушаалын хуулбар, бусад баримт бичиг, зөөврийн компьютер (laptop), албан паспорт, иргэний болон ажлын үнэмлэх зэргийг биедээ авч явна.

1.2 Зайлшгүй, яаралтай нөхцөл байдал үүссэн тохиолдолд холбоо барих удирдах ажилтнуудын мэдээллийг авсан байна.

1.3 Зохих зөвшөөрөл бүхий баталгаатай тээврийн хэрэгсэл (автобус, такси, авто машин, галт тэрэг, нисэх онгоц, усан замын тээврийн хэрэгсэл)-ийг сонгож зорчино.

1.4 Техникийн хувьд бүрэн бүтэн, эвдрэл гэмтэлгүй, засвар үйлчилгээ хийгдсэн, техникийн үзлэгт хамрагдсан тээврийн хэрэгслээр зорчино.

1.5 Тухайн зорчих улс орон, орон нутгийн цаг агаарын урьдчилсан мэдээг авч нөхцөл байдалд тохируулан хувийн бэлтгэл хангасан байх;

1.6 Авто тээврийн хэрэгслээр зорчих тохиолдолд Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийг сахин биелүүлэх, мөрдлөг болгох, тухайн тээврийн хэрэгслийн жолоочоос холбогдох дүрэм, журмыг биелүүлэхийг шаардах;

1.7 Авто тээврийн хэрэгслийн суудлын даруулга, бүсийг зүүж хэвших, салхивч цонхоор толгой, гараа гаргахгүй байх, хог, хаягдал ил задгай хаяхгүй байх;

1.8 Албан томилолтын хугацаанд согтууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл хэрэглэхийг хатуу хориглоно. Эдгээр хориглосон зүйлсийг хэрэглэхгүй байхыг тээврийн хэрэгслийн жолоочоос мөн шаардах, шаардлагатай тохиолдолд байгууллагын удирдлагад энэ талаар нэн даруй мэдэгдэнэ.

1.9 Жолоочийн анхаарлыг татах үйлдэл хийхээс зайлсхийж, жолоо барьж байх үедээ утсаар ярих, бусад анхаарал сарниулах техник, хэрэгсэл ашиглахгүй байхыг жолоочоос шаардах.

1.10 Явганаар зорчих, зам хөндлөн гарах тохиолдолд гэрлэн дохиогоор болон зөвшөөрөгдсөн гарц, гармаар гарч байх;

1.11 Тухайн улс орон, орон нутгийн түүх соёл, уламжлал, ёс заншлыг хүндэтгэх, соёлын биет өв үзмэрийг үзэж сонирхохдоо гараар хүрч, гэмтээхээс болгоомжлох;

1.12 Нийтийн тээврийн хэрэгслээр зорчих үедээ биеэ зөв авч явах, бэлэн мөнгө, үнэт эдлэл, гар утас, бусад (зөөврийн компьютер, албан паспорт, иргэний болон ажлын үнэмлэх, түлхүүр) эд зүйлээ эзэнгүй орхих, гэмт этгээдийн анхааралд өртөхгүй байхад анхаарах;

1.13 Авто тээврийн хэрэгсэлд эвдрэл гэмтэл гарч саатах, хээр гадаа хоноглох тохиолдолд эрсдэлийг урьдчилан тооцож хөдөө, орон нутагт явахдаа аяны хөнжил, хэрэгсэл, майхан зэргийг авч явах;

1.14 Ариун цэвэр, ахуйн хэрэглээний зүйлс, хэрэгцээт ойр зуурын эм, боолт (лент) зэргийг авч явах;

1.15 Холбоо барих утсаа байнга цэнэгтэй, нээлттэй байлгах. Мөн харилцаа холбооны сүлжээгүй газарт холбооны ямар хэрэгсэл ашиглахаа төлөвлөсөн байх;

1.16 Тухайн зорьсон газар, орон нутаг руу аль болох баталгаат, аюулгүй байдлыг хангасан замыг сонгож явах; /гол, мөрөн, нуурын мөстсөн хэсэг, шавар шалбаагтай хэсгээр зорчихгүй байх гэх мэт/

Хоёр. Тээврийн хэрэгслийн жолоочид өгөх зааварчилгаа:

2.1 Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийг сахин биелүүлэх,

2.2 Өдрийн цагаар буюу нартай байгаа үед замд гарч явах;

2.3 Замд гарахын өмнө орон нутгийн цаг агаарын урьдчилсан мэдээг авсан байх;

2.4 Албан томилолтоор зорчихдоо батлагдсан зам, маршрутыг сонгож зорчино. Авто тээврийн хэрэгслийн хурдыг тохируулахдаа тухайн авто замын хэсгийн зөвшөөрөгдсөн хурдны дээд хязгаараас хэтрүүлэлгүй зорчих;

2.5. Авто зам дээр ажил, үүрэг гүйцэтгэж байгаа хүн, явж байгаа мал, амьтны дэргэдүүр өнгөрөхдөө хурдаа хасаж, түүнд болон өөрсдөдөө аюул, осолтой байдал үүсгэхгүйгээр зорчих;

2.6 Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар эрх бүхий этгээдээс тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх,

2.7 Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж чадахааргүй өвчтэй буюу ядарсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцохгүй байх,

2.8 Техникийн эвдрэл, гэмтэл, зөрчилгүй байхаар тээврийн хэрэгслийнхээ бүрэн бүтэн байдлыг хангах, замд гарахаас өмнө тогтмол шалгаж байх;

2.9 Авто тээврийн хэрэгслийн хаалгыг түгжилгүй, онгорхой орхихоос зайлсхийж, хаалгыг тогтмол хааж, түгжиж байх,

2.10 Автозам дээр болон түүний ойр орчимд түр зогсох үедээ тээвэрлэн яваа зорчигчдод аюул учруулахгүй байх зааварчилгаа өгөх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж зогсолт хийх;

2.11 Авто тээврийн хэрэгслийн тоормосны систем, жолоодлогын хүрдний механизм ажиллахгүй болсон, эвдэрсэн, харанхуй үед болон үзэгдэх орчин хязгаарлагдсан нөхцөлд хол, ойрын буюу ар талын дохионы гэрэл асахгүй болсон, цас, бороо орж байгаа үед жолооч талын шил арчигч ажиллахгүй зэрэг нөхцөл байдал үүссэн тохиолдолд хөдөлгөөнөө үргэлжлүүлэхийг хориглоно.

2.12 Хөдөлгөөнд оролцож байх үед тээврийн хэрэгсэлд дээр дурдсанаас бусад гэмтэл тохиолдвол түүнийг засах, хэрэв бололцоогүй бол аюулгүй байдлыг хангаж аль ойр байгаа зогсоол (гараж) буюу засварын газарт очих хүртэл хөдөлгөөнөө үргэлжлүүлэхийг зөвшөөрнө.

2.13 Аян замд явахад автомашинтайгаа цас, шаварт суух, шөнө орой төөрөхөөс болгоомжил;

2.14 Авто тээврийн хэрэгсэлд байх шаардлагатай эд зүйлсийг бэлэн байлгах (татлага тросс, домкрат, ослын пуужин, нөөц дугуй, дугуйн нөхөөс, багаж хэрэгсэл);

2.15 Газрын зураг болон зам заагч төхөөрөмж (GPS-тэй явах);

2.16 Гол ус, цасны гүнийг урьдчилан үзэхгүйгээр гатлах гэж оролдохгүй байх;

2.17 Цасан болон шороон шуургатай, цаг агаарын хүнд нөхцөлд замд гарахыг хориглох бөгөөд замд байгалийн гэнэтийн үзэгдэл тохиолдсон үед төөрөхөөс сэргийлж замд хамгийн ойр байрлах айл, хот суурин газрыг олж байрлах, газар орон нутгийн талаар мэдээлэл авах;

2.18 Хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой хохирол учирсан байж болзошгүй зам тээврийн осолтой таарсан тохиолдолд бололцоотой тусламж үзүүлэх, цагдаа, эмнэлгийн байгууллагад яаралтай мэдэгдэх, зам тээврийн осолд өртсөн хүнд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх, эмнэлэгт яаралтай хүргэх.

Гурав. Зочид буудал, орон байранд байрлах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа:

3.1 Зочид буудалд байрлаж хоноглох үедээ хаалга цонхыг сайтар шалгах, хааж түгжиж байх, өрөөний хаалга автоматаар түгжигдэхээс болгоомжил;

3.2 Зочид буудлын өрөөний эд зүйлийг эвдэж, гэмтээхгүй байх;

3.3 Байрласан газар, зочид буудлаас түр гарах тохиолдолд хаяг, байршлыг сайтар тогтоож, шаардлагатай тохиолдолд хаяг, байршил бүхий танилцуулгыг биедээ авч явах;

3.4 Өрөөндөө танихгүй хүнийг оруулахгүй байх, үл таних хүнийг дагаж явахаас зайлсхийх;

3.5 Гэмт халдлагад өртвөл цагдаа, хууль сахиулах байгууллага, эмнэлэг, (102, 103, 105 зэрэг тусгай дугаарт мэдэгдэх) тухайн улсад суугаа өөрийн орны элчин сайдын яам, консулын газарт нэн даруй мэдэгдэх;

3.6 Тухайн газрын гудамж, талбайд олон хүн цугларсан, олон нийтийн бослого үймээн болсон газарт очихгүй байх, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн байж болзошгүй этгээдээс аль болох зайлсхийж хувийн аюулгүй байлдлаа хангах, гадаад улсад зорчихдоо бусдын дайвар ачааг авч явахгүй байх;

3.7 Өрөөнд галт зэвсэг, (үүнд үзмэр хэлбэрээр хадгалагдаж байгаа зэвсэг хамаарна) тэсэрч дэлбэрэх бодис, дэгдэмхий хий хадгалж байгаа эсэхийг шалгах, хүйтэн зэвсэг (хутга, хурц үзүүр бүхий зүйл) хадгалж байгаа эсэхийг шалгах;

3.8. Зэрлэг ан амьтанд хазуулах, мал, амьтны гоц халдварт өвчлөлд өртөхөөс болгоомжилж анхаарах;

3.9 Хорио цээр тогтоосон, гоц халдварт өвчний бүс нутагт зорчихгүй байж, халдвараас сэргийлэх, ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж байх;

3.10 Холбоо барих хэрэгсэл ашиглах боломжгүй газарт саатсан, осолдсон, гэмтсэн тохиолдолд хамгийн ойр орших айл, хот суурин руу тусламж дуудах;

3.11 Удирдлагын шийдвэр, зааврын дагуу онцгой тохиолдолд ажлын төлөвлөгөө, маршрут өөрчлөгдвөл багийн ахлагч нь байгууллагын удирдлагад заавал мэдэгдэх;

Дөрөв. Албан томилолтоор ажиллах үед танихгүй газар, орон нутаг болон барилга байгууламж, үйлдвэрийн орчинд ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа:

4.1 Тухайн ажил үүргийг аюулгүй гүйцэтгэхэд тохирсон хувийн хамгаалах багаж, хэрэгслийг бүрэн өмсөх, зориулалтын дагуу зөв хэрэглэх, өмсөж хэрэглэхийг бусдаас шаардах;

4.2 Тухайн байгууллагын талаарх мэдээллийг урьдчилан сайтар судалж мэдсэн байх;

4.3 Тухайн байгууллагын аюулгүй ажиллагааны зааварчилгаатай танилцсан байх;

4.4 Тухайн байгууллагын ажилтны удирдлага дор барилга байгууламж, үйлдвэрийн орчинд ажиллах;

4.5 Тухайн байгууллагын осол гарч болзошгүй гэж үзсэн тохиолдолд тухайн хариуцсан ажилтанд мэдэгдэх, түүнд ойртохгүй байх.

Тав. Ослын үед үзүүлэх анхны тусламж, авах арга хэмжээ:

5.1 Ямар ч үед сандарч тэвдэлгүй аль болох тайван байх, томилолтын баг бүрэлдэхүүнүүдийг бүртгэх, эрүүл мэндийн байдлыг лавлах;

5.2 Авто тээврийн хэрэгслээс бензин, шатамхай шингэн асгарч буй эсэхийг шалгах, гишүүдийг аюулгүй зайд холдуулах, тэсэрч дэлбэрэхээс урьдчилан сэргийлэх;

5.3 Осолд өртсөн хүнийг тайван байлгах, шаардлагатай үед хиймэл амьсгал хийж, чөлөөтэй амьсгалах нөхцөлөөр хангах, эмнэлгийн тусламж иртэл хөдөлгөөнгүй байлгах;

5.4 Цус алдаж буй тохиолдолд түүнийг зогсоох, боолт хийх зэрэг арга хэмжээ авах, шархыг спиртээр ариутгаж боолт тавих.